



# Миний Өв биднийх ...



UNESCO/Japan Funds-in-Trust for  
Education for Sustainable Development

Улаанбаатар хот  
2009

## **Миний өв биднийх ...**

Боловсруулсан:  
Зохиомжилсон:

Ц.Самдан  
Е.Батчулуун  
З.Тогтохмаа

Эх бэлтгэл:

Ц.Баяржаргал

---

Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төвийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Хэвлэлийн техникч:  
Хэвлэгч:  
Дэвтэрлэгч:

З.Пүрэвсүрэн  
Ж.Өлзийсайхан  
Ж.Нямжав


## СОЁЛЫН ӨВ

Хүн төрөлхтөн бүтээн бий болгосон үнэт зүйлс, соёлын өвөө хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн өгч байх нь хүн төрөлхтөн, улс үндэстэн оршин тогтнох, хөгжин дэвжих үндэс нь болдог байна. Нэгэн үндэстний бүтээсэн буюу эзэмшиж байдаг байгалийн болон соёлын өв нь нийт хүн төрөлхтний хувьд түгээмэл үнэ цэнэ, ач холбогдолтой байх нь олонтой. Ийм учраас түүнийг хадгалан хамгаалах явдал ганцхан тэр улс үндэстний хэрэг төдийгүй, дэлхийн нийт улс орон, хүмүүст бас хамааралтай байдаг.

Аль ч улс оронд байгаль, соёлынхоо гайхамшигт өвүүдээ янз бүрийн шатны хамгаалалтад авч хадгалж хамгаалж байдаг жишгээр монгол улс ч соёлын үнэт дурсгалуудаа улсын болоод аймаг орон нутгийн түвшинд хамгаалж хадгалж байна.

### Өвийн төрлүүд

Үеэс үед уламжлан өвлүүлж байгаа түүхэн үнэ цэнэт, дурсгалт зүйлийг өв гэж хэлж болно. Өв олон янз байдаг. Үүнийг доорх зургаас хараарай.



<b>Соёлын үл хөдлөх өв</b>	<b>Соёлын хөдөлгөөнт өв</b>
<ol style="list-style-type: none"> <li>1. Хүн амьдарч байсан оромж, отог бууц, агуй</li> <li>2. Тэдний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхрага</li> <li>3. Булш бунхан, хиргисүүр, тахилгын газар</li> <li>4. Хадны сүг зураг, бичээс</li> <li>5. Бүх төрлийн хөшөө дурсгал</li> <li>6. Эртний хот суурин, сүм хийд, уран барилга, тэдгээрийн туурь, үлдэц</li> <li>7. Археологийн дурсгал</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. Угсаатны холбогдолтой эд өлгийн зүйл</li> <li>2. Тоног төхөөрөмж, багаж зэмсэг</li> <li>3. Бичиг үсэг, дүрслэл, бичлэгийн арга хэрэгслэлээр баримтжин үлдсэн бичиг соёлын дурсгал</li> <li>4. Дүрслэх урлагийн бүтээлүүд</li> </ol>


## Үе уламжилсан өв



Манай сумын “ганган” Дамдин ёстой л үе уламжилсан арвин өвтэй хүн дээ. Эртний үе уламжилсан эд хэрэглэдэг болохоор нь манай сумынхан “ганган” хэмээх хочийг нэрнийх нь өмнө зүүчихсэн хэрэг л дээ.

Эмэг эхээс нь өвлөгдөн ирсэн энэ хүрд Дамдингийн хамгийн нандин өв.

Мөнгөн хяр, арван цагаантай жийжүү дөрөө, нанжин гахай гөлөмтэй энэ эмээлийг 30 жилийн өмнө цэргээс ирэхэд нь аав нь төхөөрч өгсөн гэлцдэг. Одоо гөлөм нь хуучирч мөнгөн хяр, баавар нь элэгдэж мөлийсөн нь бүр ч эртнийх гэдгийг гэрчилнэ. Эртний эдлэл үнэ цэнэтэй болсон өнөө үед ч ...



“Ганган” Дамдин гаанс, тамхины хэрэгсэл, хэт хутгаа тэр болгон ч зүүгээд байдаггүй нь хэрхэн нандигнадгийн шинж. Цагаан сар, наадам гэхчлэн онцлог үед л гоёдог юм. Энэ нь ч аргагүй. Ийм үнэт өвийг хайрлаж гамнах хэрэгтэй шүү дээ.

Харин таван үе дамжсан чүнчигноров хөөргөө бол биенээс салгахгүй шүү.



Тэгсэн мөртлөө 40 гаруй жилийн өмнө хурдан морь унахдаа барьж байсан ташуураа гэрийн хоймортоо уннд байнга хавчуулдаг нь орж гарсан хүмүүсийн нүдийг өөрийн эрхгүй татдаг. Ач хүүдээ өвлүүлнэ гэж ярьдаг юм.



Ингэхээр өв гэдэг бол заавал үнэтэй цайтай байх албагүй ажээ. Аливаа дурсгалтай, ерөөлтэй, түүхтэй зүйлс болгон л өв шүү дээ.

Надад ч гэсэн өвөг дээдсээс минь үе дамжин ирсэн олон зүйлс бий. Тэгэхээр би ч гэсэн өөрийн гэсэн өвтэй хүн шүү.

Энд тэндгүй хуучин  
эдлэл хэрэглэл худалдаж  
авна гэсэн зар байх нь элбэг. Яагаад заавал хуучин гэж?  
Мэдээж гарын дүйтэй хүмүүс хуучин эдлэл хэрэглэл  
засан шинэ юм шиг болгоод зарж борлуулах ч юуу өөрсдөө хэрэглэдэг л  
дээ. Гэтэл сав ээжээс минь өвлөж ирсэн энэ "муу" хуучин авдрыг чинь авъя  
гээд хотоос ирсэн нэг нөхөр шалаад байсан нь ямар учиртай юм бол?  
Оюутан хүү маань ч гэсэн шинэ болгоод будчихая гэсэн санааг минь эрс  
няцаасан. Тэгэхлээр үе дамжин уламжилсан гэдэгт л гол үнэ цэнэ  
нь байгаа байх нь ээ дээ. Нээрээ өвөл хот ороход хуучин эдлэлийн  
дэлгүүрт энэнээс ч хуучин авдар их л үнэтэй байсан санагдана.  
Өвийн үнэ цэнийг мөнгө төгрөгөөр хэмжиж болдоггүй  
юм байна. Авдраа ч зардаггүй  
хэрэг ээ.



?

- Танд соёлын биет өвд тооцогдох зүйлс бий юу? Хэрэв тийм бол ямар зүйлсээ та өв хэмээн тооцох вэ? Яагаад?
- Жуулчны баазууд "эрээлж цоохорлосон" модтой гэр их барьдаг ч гадныхан харин ч хуучин, утаа тортог болсон унь ханатай гэрт тухлах дуртай. Энэ нь ямар учиртай вэ?
- Хот орон газрын зарим ресторан, бааранд дээр үеийн зэс данх сав суулга зэргийг ханандаа өлгөж "гоёх" нь олонтаа. Гэтэл бид ийм сав суулгаа аль болох "далд оруулж" шинэчлэх дуртай. Энэ зөв үү?

- За тэгэхээр  
өв гэдгийн талаар овоо  
юм мэдэж авлаа. Том  
ахын маань гэрийн утаа  
тортог болсон бургасан  
унь хана одоо цагийн  
"цоохор" модон  
гэрээс үнэтэй байх нь  
ээ?



- Харин тийм.  
Нүүдэл суудалд ганц  
нэг хорчийсон гуулин  
данх минь удах тусмаа  
л үнэ ордог сүрхий эд  
байх нь л дээ.  
За өөр чинь юу билээ  
дээ? Аа тийм  
сангийн бойпор  
эмээгийн  
байна.

## Манай нутгийн өв-Дэлхийн өв

Тэр болгон бид өөрсдөө анзаарч мэддэггүй л болохоос соёлын олон өв ч байдаг юм байна шүү дээ. Гэхдээ надад буй ганц ховор нандин зүйл ганцхан минийх ч биш манай ард түмний, улмаар нийт хүн төрөлхтөний л өв юм даа. Яагаад гэвэл энэ бүгдийг хүн л бүтээсэн.



### Соёлын өвд өөр ямар зүйлс хамаарагдах вэ?

Дээр үеэс соёл иргэншил хөгжсөн улс орон, ялангуяа Европт олон зуун жилийн настай байшин барилга, уран баримал, сүмийн барилга элбэг байдаг. Чухам тэдгээрийг үзэх гэж олон жуулчин зорьдог билээ.

Жишээ нь: Ийм газруудын нэг болох Францын нийслэл Парис хотын Нотра Дамын сүм алдарт зохиолч Александр Дюмагаас ч урт настай юм.

Харин нүүдлийн соёл уламжлалтай манай орны хувьд бол эртний үед тооцогдох хад чулуу, хөшөө дурсгал, сүм хийд элбэг. Хөдөө гадаа, хаа сайгүй тааралдах булш, хиргисүүр, хүн чулуу, овоо тахилгаас өгсүүлээд хадны сүг зураг, бичээс, буган хөшөө, сүм хийд, бурхан тахил гээд бүгд л соёлын биет өвд тооцогдоно.

Хэдийгээр он цагийн уртад элэгдэн, өгөршиж, эвдэрсэн ч эдгээрийг зөвхөн түүхийн дурсгал гэдгээр нь төдийгүй, эртний он цагийн хэлхээс, үйл явдлын баталгаа гэдгээр нь хамгаалан, хадгалах учиртай. Эдгээрийн заримаас дурдъя.

Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн Орхоны хөндийн соёлын дурсгалт газарт Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурь, шарын шашны анхны төв болох Эрдэнэ зуу хийд, Өндөр гэгээн Занабазарын байгуулсан Төвхөн хийд, Хөшөө цайдам дахь Түрэгийн цогцолборт дурсгал зэрэг олон зүйлс бий.

Хүн төрөлхтөний соёлын гайхамшигт өвүүдийг дэлхийн соёлын өв хэмээн зарлаж бүртгэн авдаг.



Хэрлэн барс хотын долоон давхар суврагын үлдэц. Энд Их хуралдай ноёдын чуулганыг хийдэг байв.

(Дорнод, Цагаан-Овоо сум)

Манай оронд байдаг соёлын томоохон зарим өвүүд

<b>Хадны зураг:</b>	Жавхлант хайрханы хадны зураг (Өмнөговь, Ханбогд) Богд уулын Их Тэнгэрийн амны хадны зураг (Улаанбаатар) Можоогийн хадны зураг (Увс, Сагил сум) Гурван цэнхэрийн агуйн зураг (Ховд, Манхан сум) Цагаан салаагийн зураг (Баян-Өлгий, Улаанхус сум) Бөхийн барилдааны зураг (Дундговь, Өлзийт сум) Их Баян уулын Бичигтийн амны зураг (Баянхонгор, Баянлиг сум)
<b>Хүн чулуу:</b>	“Ноён, хатан, хүү, бэр” хүн чулуу (Сүхбаатар, Дарьганга сум) Шивээтийн хүн чулуу (Сүхбаатар, Онгон сум) Шатар чулууны хүн чулуу (Баянхонгор, Эрдэнэцогт сум)
<b>Буган хөшөө:</b>	Дааган дэлийн буган хөшөө (Завхан, Шилүүстэй сум) Дунд жаргалантын голын хөндий дэх 5 хөшөө (Хэнтий, Өмнөдэлгэр сум)
<b>Хадны бичээс:</b>	Тайхар чулууны бичээс (Архангай, Их Тамир сум) Дуутын хар чулуун дээрх Цогтын хадны бичээс (Төв аймаг, Дэлгэрхаан сум)


Танай нутагт ямар нэгэн хадны зураг байгаа бол түүний дүрс хэлбэрийг нь сайтар ажиглаарай. Хадны зураг нь тухайн үеийн хүмүүсийн амьдралын хэв маягийг голчлон илэрхийлдэгээрээ түүхийн чухал эх сурвалж болдог юм.



Жишээ нь: Дундговь аймгийн Өлзийт суманд байдаг энэ хадны зурагт барилдаж буй бөхийг дүрсэлжээ. Тэгэхээр монгол бөх бидний өвөг дээдсийн үеэс уламжлалтайг гэрчилж байна.

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Их баян уулын Бичигтийн амны хадны зураг алдартай. Энд янгир, бугыг анчид нум сумаар харван агнаж байгааг дүрсэлсэн нь тэр үеийн хүмүүсийн амьдралд ан агнуур их чухал байсныг харуулж байна.





Увс аймгийн Сагил суманд байдаг Могоогийн хадны зурагт олон тооны үхэр, аргаль, янгирыг дүрсэлсэнээс гадна үхэр хөтлөөд явж буй хүн ч харагдана. Ингэхлээр үхрийг эрт гэршүүлсэн болж таарах нь.



Манай Ховдын Манхан суманд байдаг гурван цэнхэрийн агуй ямар гэж санана! Буга, янгираас гадна манайд байдаггүй тэмээн хяруул, бүх одос үхэр, арслан зааныг ч хүртэл дүрсэлсэн байдаг юм. Энэ зургуудыг бараг 20000 жилийн өмнө зурсан гэж эрдэмтэд үздэг юм билээ. Арай тэр үед манай оронд арслан заан байсан юм биш байгаа даа...

?

**Асуулт:** Одоо энд тэндгүй шинэ цагийн "дурсгал" болох суварга босгох нь элбэг болжээ. Энэ нь соёлын өв мөн үү? Аль эсвэл...

Наймаа арилжаа хийж  
нэлээд хөрөнгөжсөн нэг найз маань гурван жилийн  
өмнө өөд болсон аавдаа зориулж  
сумын хойшно толгодын оройд их л том суварга  
босгож, түүндээ чамгүй мөнгө зарцуулсан хэмээн  
сайрхах юм. Харин сургуулийн багш найз маань "иш  
хайран ч мөнгө, үүний оронд баруун голын  
цаадах айлуудын дунд ганц жижиг  
цэцэрлэгийн байшин барьсан бол хойч үедээ ч  
хэрэгтэй, тэгээд ч ном эрдэмтэй явсан аавынх нь сүнс  
баярлах байсан даа" гэх юм. Нээрээ л  
бодоод байхад багш найзын  
маань хэлдэг  
үнэн дээ.





Эртний булш, хиргисүүр нь тухайн үеийн нийгэм, хүний амьдралын гэрч нотолгоо болдог соёлын үнэт өв юм. Гэвч ийм булш, хиргисүүрийг монголчууд дураараа ухаж төнхдөггүй сайхан уламжлалтай тул өнөөг хүртэл хадгалагдсаар иржээ. Зарим булшнаас сумны зэв, олом, бүсний арал, товруу, сав суулга, сур ширэн эдлэл гардаг ч эдгээр нь олон жилийн турш дарагдсан тул тун хэврэг.

Иймд мэргэжлийн хүмүүс тусгай багаж төхөөрөмж ашиглан, нарийн аргаар малтлага хийдэг. Ингэхээр булш, оршуулга ч бас соёлын өв юм даа. Иймд нутаг орондоо байгаа булш, хиргисүүрийг хамгаалж байх нь та соёлын өвийнхээ үнэ цэнийг улам л өргөж байна гэсэн үг.

Танайд өвөг дээдсээс хадгалж ирсэн судар ном бий юу? Бичиг соёлын ийм зүйлс нь **соёлын баримтат өвд** тооцогдоно. Жишээ нь: манай улсын үндэсний номын сан, музей, архив зэрэгт хадгалагдаж буй XIII зууны үед зохиосон **“Алтан товч”**, **“Есөн эрдэнийн ганжуур”** зэрэг нь соёлын үнэт баримтат өв юм.



## **Соёлын өвийг хамгаалах, хадгалахын тулд бид юу хийх хэрэгтэй вэ?**


- Хадны бичээс, сүг зураг бүхий газраас чулуу шороо зөөхгүй байх
- Хүн чулуу, буган хөшөө зэргийг хадаг яндраар “дарахгүй”, байгаа төрхөөр нь хадгалах
- Түүхийн дурсгалт газар, сонин тогтоц, бичээс, зураг бүхий хад чулуун дээр нэр усаа бичиж, цоохорлохгүй байх
- Булш, хиргисүүрийг дураараа ухаж онгичихгүй байх
- Овоон дээр уусан архиныхаа шил, цаастай чихэр тавих нь та тэнд хогоо л хаяж байна гэсэн үг. Зарим газар модон таяг олон байх нь ч эвгүй харагддаг. Хадгийг ч хамаагүй газар уяж, орхиж болдоггүй гэдэг. Цэвэр, цэмцгэр овоонд сүслэн бишрэх нь сэтгэлд ч сайхан.

?

Зарим газар хүн чулуу, гэрэлт хөшөө, буган хөшөө зэргийг элдэв өнгийн хадгаар ороосон нь эгээ л "мануухай" аятай харагдах юм. Хадагны цаана юу байгааг гадны хүн бол бүр ч ойлгохгүй дээ. Энэ нь хамгаалж байгаа хэлбэр мөн үү? Аль эсвэл...



"Ноён, хатан, хүү, бэр" хүн чулуу  
(Сүхбаатар, Дарьганга сум)



Шатар чулууны хүн чулууд  
(Баянхонгор, Эрдэнэцогт сум)

?

Дээрх хоёр зурагт үзүүлсэн хүн чулууны аль нь илүү унаган төрхөөхөө хэрэгдэж байна вэ? Хадаг яндараар навсайтал дарах нь зөв үү?

Өвөлжөөний ард байгаа  
хүн чулуу шувууны сангасаар хучигдсан  
байна лээ.  
Түүнийг нь цэвэрлэж, эртээд ирсэн машинтай  
улсын унжуулсан шар цэнхэр  
хадагнуудаас нь  
салгая байз.





Нэг удаа  
авдар дээр байсан  
бага хүүгийнхээ  
түүхийн сурах бичгийг эргүүлж  
үзэж байгаад үүнийг мэдсэн юм.

Та ч бас мэдээд аваарай.

### **Гандантэгчинлэн хийд**

Их хүрээний Далхын дэнж гэдэг газар V Богд Жибзундамба 1838 онд үндэслэн байгуулсан тус хийдийн гол шүтээн нь Очирдарь бурхан. Хийд одоо гүн ухааны 3 дацан, бурханы шашны их дээд, дунд сургууль, эмч болон зурхай зэрэг бурханы шашны эрдэм ухааны сургууль, дацангуудыг эгнээндээ багтаасан, дотоод, гадаадын сүсэгтэн олон, жуулчид, гийчдийн эргэл мөргөл хийдэг, үзэж сонирхдог шашин соёлын томоохон төв юм.

### **Амарбаясгалант хийд**

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг дэвсгэрт орших Амарбаясгалант хийд нь анхдугаар Богд Өндөр Гэгээн Занабазарт зориулсан ариун дагшин шүтээн, Монголын түүх соёлын хосгүй нандин дурсгалын нэг билээ. Сүм хийдийг байгаль орчинтой нь зохицуулж, уул ус, ургамал, ой хосолсон үзэсгэлэнт газар сонгон бүтээдэг монгол уламжлалын сонгодог жишээ нь энэ хийд юм. Хийдийг 1944 онд улсын хамгаалалтанд авч, ЮНЕСКО-гийн Дэлхийн Өвд бүртгүүлэх Монголын жагсаалтанд оруулсан байна.

### **Төвхөн хийд**

Төвхөн хийд Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын нутагт Шивээт уулын оройд цачим эгц хадан цохион дунд байгальтайгаа нэн зохицон оршдог юм. Чингис хааны алтан ураг Өндөр гэгээн Занабазар хийдийг 1653 онд үндэслэн байгуулсан бөгөөд тэрээр нямба бясалгал хийж, уран бүтээлийнхээ санааг гаргаж байсан ариун газар юм. Хийдийг 1971 онд аймгийн, 1994 онд улсын хамгаалалтад авсан ба 2003 онд Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын бүрэлдэхүүн хэсэг болон Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн юм.



Монгол охидын сонгодог дүр  
**ЦАГААН ДАР ЭХ**



Эх хүний гоо сайхны сонгомол дүр  
**НОГООН ДАР ЭХ**



За ингээд уншиж судалж,  
үзэж харснаа яриад байвал  
мундахгүй их.

Одоо та яагаад би өөрийгөө бас таныг  
баян хүн гээд байсны учрыг та олсон  
байх аа.

Бид чинь хайрлаж хамгаалж,  
хүндлэн дээдэлж явахаас өөр аргагүй  
олон сайхан өв соёлтой хүмүүс.  
Өвөг дээдэс маань тэдгээрийг бидэнд  
хүлээлгэж өгсөн,  
бид бас үр хойчдоо үлдээх ёстой.

Гал түймэр тавих,  
хөдөө хээр ил задгай байгаа соёлын  
дурсгалуудыг дур мэдэн ухаж төнхөх,  
хамгаалалтын хайс, хашааг нь эвдэж  
сүйтгэх, өвийн газар нутагт малаа  
оруулах, хулгайгаар ан хийх, түлээ мод  
бэлтгэх зэрэг нь байгаль,  
соёлын өвүүд устаж үгүй болох,  
доройтон мөхөх аюултайг та бид  
мэдэж, хамгаалах ёстой.

Энэ бол БИДНИЙ ҮҮРЭГ.

